БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021/8/СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2021 он | Газрын Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br>Аудитор: Б.Энхтөр<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....10
3. Аудитын тайлан....11
3.1. Ерөнхий зүйл....11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....12
3.4. Материаллаг байдал ....12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....14
3.7. Шилэн дансны мэдээлэл....15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.9. Аудитын илрүүлэлт....15
Залруулсан алдаа....15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....16
Аудитын зөвлөмж....16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....16
4. Менежментийн захидал....17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....18

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.08 № 37

танай ____________-ны №____________т

БУЛГАН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА А.ГАНТӨМӨР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020075

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, заавры дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **69,702,426.15** | **80,027,182.15** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 1,108,866.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 108,866.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 1,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 1,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 69,702,426.15 | 78,918,316.15 |
| **351** | **Түүхий эд материал** | 60,236,159.15 | 60,236,159.15 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 60,236,159.15 | 60,236,159.15 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,066,267.00 | 18,282,157.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,108,700.00 | 1,865,560.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,517,855.00 | 5,517,855.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 880,000.00 | 1,520,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,519,712.00 | 9,375,742.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 40,000.00 | 3,000.00 |
| 35600 | Мал амьтад | 400,000.00 | 400,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **665,156,691.83** | **748,931,985.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 665,156,691.83 | 748,931,985.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 605,738,613.83 | 693,295,157.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 555,469,883.97 | 555,469,883.97 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -28,428,759.84 | -51,124,186.37 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 219,664,965.00 | 158,845,523.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -182,701,853.88 | -34,726,476.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 133,643,999.60 | 95,666,816.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -99,265,878.64 | -40,446,330.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,174,334.00 | 13,007,510.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -14,187,576.67 | -7,729,883.71 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,372,000.00 | 10,372,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,002,499.71 | -6,039,699.67 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 59,418,078.00 | 55,636,828.00 |
| 39301 | Програм хангамж | 25,830,000.00 | 25,830,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -22,048,750.00 | -25,830,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 55,636,828.00 | 55,636,828.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **734,859,117.98** | **828,959,167.25** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **734,859,117.98** | **828,959,167.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 734,859,117.98 | 828,959,167.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 438,496,996.60 | 438,496,996.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 438,496,996.60 | 438,496,996.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 26,386,906.82 | 10,912,283.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 26,386,906.82 | 26,432,506.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -15,520,223.73 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 269,975,214.56 | 379,549,887.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **734,859,117.98** | **828,959,167.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **582,366,700.00** | **568,905,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **25,427,100.00** | **31,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 24,139,500.00 | 31,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,139,500.00 | 31,000,000.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,090,000.00 | 31,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **556,939,600.00** | **537,905,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,250,000.00 | 4,950,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 250,000.00 | 950,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 517,689,600.00 | 532,955,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 517,689,600.00 | 532,955,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **594,136,122.83** | **584,425,923.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **594,136,122.83** | **584,425,923.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 574,985,240.83 | 575,305,580.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 375,834,600.00 | 403,514,914.00 |
| 210101 | Үндсэн цалин | 292,243,200.00 | 361,382,797.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,943,400.00 | 27,730,717.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,648,000.00 | 14,401,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,979,300.00 | 51,538,936.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,945,900.00 | 46,136,983.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,758,300.00 | 1,390,786.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,006,700.00 | 1,092,467.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 751,700.00 | 262,323.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,516,700.00 | 2,656,375.95 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,984,650.00 | 37,142,314.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,938,300.00 | 7,571,931.42 |
| 210302 | Түлш, халаалт | 32,046,350.00 | 29,570,383.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,384,038.00 | 9,997,514.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,451,050.00 | 1,197,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,377,388.00 | 6,160,402.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,620,000.00 | 2,409,989.84 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 852,600.00 | 229,483.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,466,300.00 | 1,679,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,466,300.00 | 1,679,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,999,700.00 | 2,726,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,999,700.00 | 2,726,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,616,568.00 | 7,944,443.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,920,000.00 | 7,176,770.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 172,620.00 | 268,020.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 292,575.00 | 277,123.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 113,373.00 | 134,530.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,720,084.83 | 60,761,057.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,137,600.00 | 3,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 275,000.00 | 556,178.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,307,484.83 | 57,204,879.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19,150,882.00 | 9,120,343.26 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,851,100.00 | 3,438,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,440,000.00 | 3,438,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 5,681,843.26 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,769,422.83** | **-15,520,223.73** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-21,144,422.93** | **-15,520,223.73** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **558,276,700.00** | **537,905,700.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **556,939,600.00** | **537,905,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,250,000.00 | 4,950,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 250,000.00 | 950,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 517,689,600.00 | 532,955,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 517,689,600.00 | 532,955,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **523,276,700.00** | **537,545,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **523,276,700.00** | **537,545,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **504,125,818.00** | **528,425,456.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 375,834,600.00 | 403,836,747.00 |
| 210101 | Үндсэн цалин | 292,243,200.00 | 359,755,893.53 |
| 210102 | Нэмэгдэл | 61,943,400.00 | 30,362,953.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,648,000.00 | 13,717,899.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,979,300.00 | 51,578,842.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,945,900.00 | 46,176,889.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,758,300.00 | 1,390,786.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,006,700.00 | 1,092,467.63 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 751,700.00 | 262,323.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,516,700.00 | 2,656,375.95 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,558,000.00 | 42,905,873.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,938,300.00 | 7,571,931.42 |
| 210302 | Түлш, халаалт | 32,619,700.00 | 35,333,942.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,006,750.00 | 12,560,972.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,494,050.00 | 1,960,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,980,100.00 | 8,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,680,000.00 | 2,403,989.84 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 852,600.00 | 196,483.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,718,300.00 | 2,315,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,718,300.00 | 2,315,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,999,700.00 | 2,726,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,999,700.00 | 2,726,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,616,568.00 | 7,944,443.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,920,000.00 | 7,197,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 172,620.00 | 268,020.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 292,575.00 | 277,123.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 113,373.00 | 113,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,412,600.00 | 4,556,178.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,137,600.00 | 4,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 275,000.00 | 556,178.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,150,882.00** | **9,120,343.26** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,851,100.00 | 3,438,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,440,000.00 | 3,438,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 5,681,843.26 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,681,843.26 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,000,000.00** | **359,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **35,000,000.00** | **359,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **35,000,000.00** | **359,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 35,000,000.00 | 359,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 359,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-35,000,000.00** | **-359,900.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **438,496,996.60** | **269,975,214.56** | **26,386,906.82** | **00.00** | 734,859,117.98 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **438,496,996.60** | **269,975,214.56** | **26,386,906.82** | **00.00** | 734,859,117.98 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 45,600.00 | 00.00 | 45,600.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **438,496,996.60** | **269,975,214.56** | **26,432,506.82** | **00.00** | 734,904,717.98 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 109,574,673.00 | 00.00 | 00.00 | 109,574,673.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -15,520,223.73 | 00.00 | -15,520,223.73 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **438,496,996.60** | **379,549,887.56** | **10,912,283.09** | **00.00** | 828,959,167.25 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 00.00 | 00.00 | 532,955,700.00 | 528,223,856.74 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 532,955,700.00 | 528,223,856.74 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 529,515,700.00 | 524,785,356.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 00.00 | 405,929,200.00 | 403,836,747.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 00.00 | 315,606,300.00 | 359,755,893.53 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 74,989,300.00 | 30,362,953.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 15,333,600.00 | 13,717,899.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 00.00 | 52,121,200.00 | 51,578,842.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 00.00 | 35,442,400.00 | 46,176,889.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 4,169,700.00 | 1,390,786.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 3,335,800.00 | 1,092,467.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 833,900.00 | 262,323.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 8,339,400.00 | 2,656,375.95 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 00.00 | 43,185,600.00 | 42,905,873.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 | 8,695,600.00 | 7,571,931.42 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 | 34,490,000.00 | 35,333,942.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 00.00 | 12,921,600.00 | 12,920,872.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 00.00 | 1,960,500.00 | 1,960,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 2,404,600.00 | 2,403,989.84 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 556,500.00 | 556,383.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 2,315,900.00 | 2,315,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 2,315,900.00 | 2,315,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 2,945,900.00 | 2,726,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 2,945,900.00 | 2,726,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 00.00 | 9,539,400.00 | 7,944,443.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 8,637,200.00 | 7,197,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 268,100.00 | 268,020.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 404,000.00 | 277,123.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 00.00 | 88,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 00.00 | 142,100.00 | 113,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 0.00 | 556900.00 | 556178.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 556,900.00 | 556,178.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 3440000.00 | 3438500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 3,440,000.00 | 3,438,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 00.00 | 3,440,000.00 | 3,438,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 532,955,700.00 | 532,955,700.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 532,955,700.00 | 532,955,700.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 532,955,700.00 | 532,955,700.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 00.00 | 00.00 | 40.00 | 40.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 36.00 | 35.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 03.00 | 04.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **3,000,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **3,000,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 3,000,000.00 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 3000000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,000,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 4950000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 4,950,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 950,000.00 | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг А.Гантөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд тээвэр шатахуун, томилолтын данс, санхүүгийн тайлангийн уялдаа, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дахин давтахгүй байх талаар төлбөрийн акт, зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 02-ноос 2021 оны 02 дугаар сарын 05–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 01/27 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Аймгийнхаа байгалийн баялгийг түүний нөөцийн хэмжээ, даацтай нь нийлүүлэн зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй хадгалж байх, ард иргэдэд өөрсдөө орон нутгийнхаа байгалийн баялгийг ашиглах хамгаалахтай холбогдсон экологийн мэдлэг олгох таатай орчинг бүрдүүлэх нь байгаль орчин, аялал жуулчлалын газрын эрхэм зорилго мөн” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойн хамгаалах нөхөн сэргээх
- Уул уурхай
- Аялал жуулчлал
- Усны нөөц
- Хог хаягдал, химийн хортой бодис
- Ан амьтан хамгаалал

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- НББ тухай хууль
- Өмчийн тухай хууль
- Худалдан авах ажиллагааны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- 2020 оны Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 11079.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 70.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 11008.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухай бүрд нь мэдээлж зөрчил илрээгүй байна.

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд 1 гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 582366.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5823.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94100.05 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансанд үнэ төлбөргүй орлого, авлага үүссэн зэрэг хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | 1108.8 | 1108.8 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 69702.4 | 78918.3 | -9215.9 |
| Үндсэн хөрөнгө | 1016792.01 | 914828.6 | 101963.4 |
| **Нийт хөрөнгө** | 734859.1 | 828959.2 | 94100.1 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 734859.1 | 828959.2 | 94100.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 734859.1 | 828959.2 | 94100.1 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж 0.0 мянган төгрөг өсөлт, бууралтгүй.

Авлага дансны үлдэгдэл 1108.8 мянган төгрөг болж 1108.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны дансны үлдэгдэл, ажилчидтай холбоотой авлага үүссэн шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 1108.8 мянган төгрөгийг 2020 онд үүссэн. 1000.0 мянган төгрөгийн байгууллагаас, 108.8 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлага байна.

Нийт авлагаас 1108.8 мянган төгрөгөөс барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78918.3 мянган төгрөг болж 9212.9 мянган төгрөгөөр өссөн нь нүүрс, шатахууны нөөцөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 78918.3 мянган төгрөг, 2020 онд худалдаж авсан бараа материал байна.

Энэ нь нэгдсэн халаалтад холбогдоогүй халаалттай тул нүүрсийг нөөцөлсөн байна. Оны эцэст 78918.3 мянган төгрөгийн нүүрс, шатахуун худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь оны эхэнд төсөв сарын сүүлээр ордог тул оны эхний шатах, тослох материалаа нөөцөлж авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 914828.6 мянган төгрөг болж 101963.4 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээ болон ашиглагдахгүй байгаа хөрөнгийг акталсан шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 359.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн ОБЕГ-ын улсын нөөцөөс фургон авто машин 31000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталсан 30125.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансанд үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 828959.2 мянган төгрөг болж 94100.1 мянган төгрөгөөр өссөн нь дахин үнэлгээ шалтгаалжээ. Энэ нь дахин үнэлгээ хийснээр үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж ашиглаж байна.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13461.0 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө дээр үнэ төлбөргүй ирсэн авто машины орлого байна. Энэ нь ОБЕГ-ын улсын нөөцөөс 31000.0 мянган төгрөгөөр үнэлсэн үндсэн хөрөнгө байна.

Нийт зардал өмнөх оноос 9710.2 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дахин үнэлгээ буюу үндсэн хөрөнгийн зардлууд байна. Энэ нь дахин үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 45.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь дахин үнэлсэн хөрөнгийг актлахад өмнөх оны үр дүнд нөлөөлсөн нөлөөлөл шалтгаалсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 555660.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 555660.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 17704.7 мянган төгрөгөөр бууруулж 537955.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвөөс томилолт, урсгал зардал, НД 1 хувь, хангамжийн бараа материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зэрэг данснаас хасагдаж батлагдсан байна. Ковид-19 вируснээс шалтгаалсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

Гүйцэтгэлээр санхүүжилт аваагүй, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 950.0 мянган төгрөг, нийт 950.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5681.8 мянган төгрөг буюу 1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 4600.0 мянган төгрөгөөр, бусад бараа ажил үйлчилгээний зардлыг 1081.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого

Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого батлуулаагүй байна.

*Хүснэгт 2* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Тайлант оны дансны нийт төвлөрүүлэг | | 5681.8 | | |
| **Нийт дүн** | | 5681.8 | | |

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 950.0 мянга, нийт 4950.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хоггүй цэвэрхэн Монгол аяны хүрээний зар сурталчилгааны зардалд 3000.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1950.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 20 мэдээллээс хугацаандаа оруулсан 20 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж итгэмжлэл авсан тул зөрчил гараагүй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11079.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 70.4 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 11008.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Шатахууны анхан шатны баримт дээр үйл ажиллагааны зориулалт тодорхойгүй, томилолтын дуудах бичгийн баримтад хавсаргаагүй 4 зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1179.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 70.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Санхүүгийн тайлан зөрүүтэй тайлагнах, шатахуун болон томилолтыг үр ашиггүй зарцуулах зэрэг алдаанд анхаарах шаардлагатай байна. Энэ илэрсэн алдаа зөрчил нь дотоод хяналтын баг ажилладаггүйгээс алдаа зөрчил илэрч байна. Иймд дотоод хяналтын баг бүрэлдэхүүн байгуулж дотоод үйл ажиллагаа болон орлого зарлага, байгууллагын үйл ажиллагаанд хяналттай ажиллах шаардлагатай гэж үзлээ. Дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудлыг давтан хяналт хийж үзэх тул энэ асуудлуудыг давтан гаргахгүй байх тал дээр анхаарлаа хандуулж ажиллана уу.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Томилолтын данстай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Тайлант онд байгууллагаас авах авлага 1000.0, ажилчидтай холбоотой 108.8 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

1.2. *Эрсдэл:* НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

*1.3.* *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

*2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Санхүүгийн тайлан зөрүүтэй, дээд шатны байгууллагаас авах найдваргүй авлага 9900.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгасан.

*2.2. Эрсдэл*: НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

*2.3. Өгсөн зөвлөмж:* НББ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| **2021** | | | САГ-2021/8/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Томилолтын зардал илүү олгосон. | 42.0 | Төлбөрийн акт | Мэргэжилтэн | Г.Жавзмаа |
| 2 | Шатахуун үр ашиггүй зарцуулалт | 28.4 | Төлбөрийн акт | Мэргэжилтэн | Г.Жавзмаа |
| 3 | Тайлант онд үүссэн авлага | 1108.8 | Зөвлөмж | Дарга | А.Гантөмөр |
| 4 | Санхүүгийн тайлан зөрүүтэй ирүүлсэн. Дээд шатны байгууллагаас авах авлага | 9900.0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан | А.Гантөмөр<br>Г.Мягмаржав |
| 5 | Томилолт дуудах бичиггүй, шатахуун хэрэглэсэн зориулалт тодорхойгүй гүйлгээ | 0 | Залруулга | Дарга<br>Нягтлан | А.Гантөмөр<br>Г.Мягмаржав |
| **ДҮН** | | **11079.2** | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР Б.ЭНХТӨР